МЭДЭЭ · 2020 оны 2-р сарын 12

ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН АНХАН ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧ НАРТАЙ АЖИЛ ХЭРГИЙН УУЛЗАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЖЭЭ



Дундговь аймгийн прокурорын газар тус аймгийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нартай ажил хэргийн уулзалтыг 2020 оны 2 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулжээ.

Уулзалтаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд хяналт тавих ажлын талаар болон Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг нэг мөр ойлгож хэрэгжүүлэхэд гарч байгаа хүндрэл бэрхшээл, тулгамдаж буй асуудлаар харилцан санал солилцож, хууль хэрэглээний зарим тодорхой бус, зөрүүтэй ойлголтууд дээр нэгдсэн шийдэлд хүрсэн байна.

ДУНДГОВЬ АЙМГИЙН ПРОКУРОРЫН ГАЗАР

Эх сурвалж: https://prosecutor.mn/post/3026